

## ТАНИЛЦУУЛГА

“Торгох шийтгэлийг нэмэгдүүлж тооцох хугацаа, аргачлал”-ын төслийн талаар

Зөрчлийн тухай хуулийн тухай хуулийн 3.5 дугаар зүйлийн 4-т “Эрх бүхий албан тушаалтнаас оногдуулсан торгох шийтгэлийг энэ хуульд заасан хугацаанд биелүүлээгүй бол шийтгэлийн хэмжээг тавь хүртэл хувиар нэмэгдүүлнэ.” гэж, мөн зүйлийн 5-д “Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу торгох шийтгэлийг нэмэгдүүлж тооцох хугацаа, аргачлалыг Улсын ерөнхий прокурор, хууль зүй асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.” гэж тус тус заасан.

Дээрх хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан тус хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Торгох шийтгэлийг нэмэгдүүлж тооцох хугацаа, аргачлал”-ын төслийг боловсрууллаа.

Энэхүү аргачлалыг баталснаар зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд нь оногдуулсан торгох шийтгэлийг хуульд заасан хугацаанд биелүүлээгүй тохиолдолд торгох шийтгэлийн хэмжээг нэмэгдүүлэн тооцох, шийтгэл биелүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд “Эрх бүхий албан тушаалтнаас оногдуулсан торгох шийтгэлийг нэмэгдүүлж тооцох хугацаа, аргачлал тодорхой болж, эрх бүхий албан тушаалтан, шүүгчээс оногдуулсан торгох шийтгэлийн биелэлт хангагдах ач холбогдолтой юм.

--oOo--